

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2008 оны 6 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд  
газар дээрх шалгалт хийх журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2 дахь хэсэг, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталж, 2008 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2003 оны 639 дүгээр тушаалаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээр нь шалгаж үнэлгээ, дүгнэлт өгөх журам”-ыг хүчингүй болсонд тооцуулах хүсэлтийг Монголбанкинд тавьж, шийдвэрлүүлэхийг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

*/Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны  
10 дугаар сарын 22-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор  
орсон өөрчлөлтийг тусгав./*

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны  
157 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭРХ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ноос Банк бус санхүүгийн байгууллагын /цаашид ББСБгэх/-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг газар дээр нь шалгаж, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын хэрэгжилт, ББСБ-ийн санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авч ажиллахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Хорооны хянан шалгагч, улсын байцаагч нь ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээрх шалгалтын дүнгээр тохируулга хийсэн санхүүгийн тайлан тэнцэлд үндэслэн дараах үзүүлэлтүүдийг тооцож үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

- |                                       |                |
|---------------------------------------|----------------|
| 1.2.1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ      | - Capital,     |
| 1.2.2. Активын чанар                  | - Assets,      |
| 1.2.3. Удирдлагын чадвар              | - Management,  |
| 1.2.4. Ашигт ажиллагаа                | - Earnings,    |
| 1.2.5. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар | - Liquidity,   |
| 1.2.6. Зах зээлийн эрсдэлийн мэдрэмж  | - Sensitivity. |

1.3. Дээрх үзүүлэлтүүдийг тооцож үнэлгээ, дүгнэлт өгөхдөө үзүүлэлт бүрийн хавсралтад заасан үндсэн /чанарын/ болон харгалзах хүчин зүйлийг тооцох ба үзүүлэлт бүрийн хүчин зүйл тус бүрт 1 буюу сайн, 2 буюу хангалттай, 3 буюу дунд, 4 буюу хангалтгүй, 5 буюу муу гэсэн үнэлгээг өгч, тухайн хүчин зүйлийн холбогдох хувиар жигнэж, нийлбэрийг нь олох замаар үзүүлэлт бүрийн нэгдсэн үнэлгээг гаргана.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

1.4 Газар дээрх шалгалтын талаарх дүгнэлт, санхүүгийн үзүүлэлтийг үндэслэн ББСБ-ын үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын байдалд өгөх нэгдсэн үнэлгээг тус журмын 7 дугаар бүлэгт заасны дагуу холбогдох хувиар жигнэж, дараах байдлаар газар дээрх шалгалтын нэгдсэн үнэлэлтийг өгнө. Үүнд:

САЙН	буюу 1
ХАНГАЛТТАЙ	буюу 2
ДУНД	буюу 3
ХАНГАЛТГҮЙ	буюу 4
МУУ	буюу 5

1.5. Тухайн ББСБ-д газар дээрх шалгалт хийх хугацаандаа хянан шалгагч нь санхүүгийн үзүүлэлтийн өсөлт бууралт, ирээдүйн чиг хандлага, гарсан өөрчлөлтийн шалтгаан, өмнөх шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний дүнг авч үзэн нэгдсэн үнэлгээ өгөх ба цаашид баримтлах чиг хандлагыг тодорхойлно.

*/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

1.6 Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, итгэлцэл, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх ББСБ-д жилд 1-ээс доошгүй удаа газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор нэмсэн./*

## ХОЁР. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ

Хянан шалгагч нь дараах хүчин зүйлсийг үндэслэн энэ журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНД үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

### 2.1. Үндсэн буюу чанарын хүчин зүйл

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн чанарын хүчин зүйлсийг үнэлэхдээ тухайн ББСБ эрсдэлийн хүрээ болон түүний чанар, хэлбэр, эдгээр эрсдэлийг удирдах удирдлагын чадавхи зэрэгт үндэслэнэ.

2.1.1 Өөрийн хөрөнгө, нийт актив болон эрсдэлээр жигнэсэн активынзохистой харьцаа Хорооноос тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэх.

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

## 2.2. Харгалзах хүчин зүйл

2.2.1 Өөрийн хөрөнгөтэй холбогдон гарсан хууль, журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэх;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

~~а/ Хоёрдогч өглөг хэрхэн бүрдсэн, гэрээ бусад баримт бичгүүдийн бүрдэл, зөвшөөрөл авсан эсэх;~~

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./*

2.2.2 Хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан эсэх, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн болон хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орсон тухай бүр Хороонд мэдэгдэж зөвшөөрөл авч байсан эсэх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./*

2.2.3 Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахдаа Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авсан эсэх, холбогдох журмын шаардлагыг хангаж байгаа эсэх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор нэмсэн./*

2.2.4 Хаалттай өрийн бичиг гаргахдаа Хорооноос зөвшөөрөл авсан эсэх, Хорооноос тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор нэмсэн./*

## ГУРАВ. АКТИВЫН ЧАНАР

Хянан шалгагч нь дараах хүчин зүйлийг үндэслэн энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу ББСБ-ын АКТИВЫН ЧАНАРТ үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

### 3.1. Үндсэн буюу чанарын хүчин зүйл

Активын чанарт үнэлгээ, дүгнэлт өгөхдөө тэнцлийн болон тэнцлийн гадуурх хүндрэлтэй, чанаргүйд ангилагдсан, хугацаандаа төлөгдөөгүй, хуримтлуулж тооцоогүй, нөхцөл нь өөрчлөгдөж шинэчлэгдсэн актив хөрөнгийн түвшин, хандлага; активын эрсдэлийн сангийн хүрэлцээ; чанаргүй активыг тодорхойлох, удирдах болон эргэн төлүүлэх чадвар, зээл болон бусад хөрөнгө оруулалтын багцын чанар болон тараан байршуулалт /диверсификаци/; зээл болон хөрөнгө оруулалтын бодлого, заавар журмын зохистой байдал; тэнцлийн гадуурх дансаас үүсч болзошгүй зээлийн эрсдэл, актив хөрөнгийн төвлөрөл; активын удирдлагын үр дүнтэй байдал; эрсдэлийг тодорхойлох заавар журам, хяналт болон мэдээллийн систем зэргийг үндэслэнэ.

3.1.1. Нийт активт эзлэх нийт чанаргүй актив хөрөнгийн хэмжээ;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

3.1.2. Өөрийн хөрөнгөд эзлэх нийт чанаргүй актив хөрөнгийн хэмжээ;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

3.1.3. Өөрийн хөрөнгөд эзлэх актив хөрөнгийн эрсдэлийн сангийн хэмжээ;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

3.1.4. Өөрийн хөрөнгөд эзлэх активын төвлөрлийн эрсдэлийн хувь хэмжээ;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./*

3.1.5 Нийт активт эзлэх үндсэн хөрөнгийн хэмжээ.

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор нэмсэн./*

3.2. Харгалзах хүчин зүйл

3.2.1. Нийт активт орлого авчирдаггүй активын эзлэх хувь, хэмжээг тооцох;

3.2.2. Зээлийн бодлогын хэрэгжилт, Зээлийн хорооны үйл ажиллагаа буюу зээлийн эргэн төлөлт:

а/ Активын бусад эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах, хянах чадвартай эсэх;

б/ Зээлийн барьцаа хөрөнгийн хэмжээ, чанар;

в/ Холбогдох зээлдэгчдийн нийт зээлийн эрсдэл;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

г/ Шалгалт хамрах хугацаанд олгосон, төлөгдсөн зээлийн харьцаа;

3.2.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, холбогдох журамд заасан зээл болон бусад активт тавьсан хязгаарлалтуудыг хангаж байгаа эсэх;

3.2.4. Зээл түүнтэй адилтгах бусад эрсдэлтэй актив, хүлээж болзошгүй үүргүүдийг ангиллыг зохих журмын дагуу хийсэн эсэх;

3.2.5. Активын эрсдэлийн санг бүрэн байгуулж, түүнийг зөв зохистой зарцуулж байгаа эсэх;

3.2.6. Чанаргүй активын нийт активт эзлэх хувь, түүний өсөлт, бууралтын шалтгааныг тодруулах, чанаргүй активыг барагдуулах талаар авсан арга хэмжээ, өр барагдуулж буй үйл ажиллагаа;

#### ДӨРӨВ. УДИРДЛАГЫН ЧАДВАР

Хянан шалгагч нь дараах хүчин зүйлийг үндэслэн энэ журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу ББСБ-ын УДИРДЛАГЫН ЧАДВАРТ үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

##### 4.1. Үндсэн буюу чанарын хүчин зүйл

Удирдлагын чадварт чанарын үнэлгээг өгөхдөө ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой бүх үзүүлэлтүүд хангагдаж байгаа эсэх, удирдлага нь үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах чадвартай эсэхийг харгалзана.

##### 4.1.1. Энэ журмын бусад таван үзүүлэлтийн дундаж үнэлгээ;

4.1.2. Үйл ажиллагааны орлогод үйл ажиллагааны зардлын байвал зохих хувь хэмжээ;

##### 4.2. Харгалзах хүчин зүйл

4.2.1. Хорооноос өмнө хийсэн газар дээрх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, шалгалтын үр дүнгээр авсан арга хэмжээний чанар, үр дүнгийн байдал;

4.2.2. Хуульд заасан эрхүүргийн хүрээнд улс орны эдийн засаг, санхүүгийн салбарт гарч байгаа өөрчлөлтөнд зохицуулан ББСБ-ын үйл ажиллагааг удирдах чадвартай эсэх, ББСБ-ын санхүүгийн байдалд бодит үнэлэлт, дүгнэлт өгч, ББСБ-ын стратегийг эв тодорхойлж зохистой шийдвэр гаргадаг эсэх, гүйцэтгэх удирдлага нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

4.2.3. Дотоод хяналтын албаны үйл ажиллагааг эрсдэлийг илрүүлэн тогтоох, бууруулахад чиглүүлэн ажиллаж дүгнэлт гаргадаг эсэх, тус албыг байгуулсан болон удирдлагад тайлагнах зарчим нь хуульд заасан шалгуурыг хангаж байгаа болон тухайн ББСБ-ын дүрэм, журамд нийцэж байгаа эсэх;

4.2.4. Удирдлагын мэдээллийн систем үрэлдэн бий болсон эсэх, ББСБ -ын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийн талаарх мэдээллийг хэрхэн цуглуулдаг, шаардлагатай бүх мэдээллийг хамардаг, мэдээллийн үнэн зөв эсэхэд хэрхэн хяналт тавьдаг, Монголбанкны зээлийн мэдээллийн санд холбогдсон эсэх,;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

4.2.5. Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн дотоод дүрэм, заавар журмыг боловсруулж, тэдгээрийг мөрдөж байгаа эсэх;

4.2.6. ББСБ нь удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан ажилтнууд нь албан тушаалаа урвуулан ашиглаж байсан эсэх;

4.2.7. Нягтлан бодох бүрт гэлийн програм хангамжтай эсэх, санхүүгийн тайлан, мэдээг зохиож журмын дагуу зөв зохистой гаргадаг эсэх, нягтлан бодох бүртгэлийг Олон Улсын стандартын дагуу гаргахад хяналт тавьдаг эсэх;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон./*

4.2.8 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа эсэх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор нэмсэн./*

## ТАВ. АШИГТ АЖИЛЛАГАА

Хянан шалгагч нь дараах хүчин зүйлийг үндэслэн энэ журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу ББСБ-ын АШИГТ АЖИЛЛАГААНД үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

### 5.1. Үндсэн буюу чанарын хүчин зүйл

Ашигт ажиллагааны чанарыг үнэлэхдээ ашигт ажиллагааны түвшин, хандлага болон тогтвортой байдал, ашигт ажиллагааны зах зээлийн эрсдэлээс хамаарах хэлбэлзэл, эрсдэлийн сангуудын зохистой түвшин, гэнэтийн орлого, зарлагаас хамаарах ашигт ажиллагааны хамаарал зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэнэ.

*/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./*

5.1.1. Актив хөрөнгийн өгөөж (тайлант хугацааны татварын дараах цэвэр ашгийг ББСБ-ын шалгалт хамрах хугацааны нийт актив хөрөнгөд харьцуулсан харьцаа);

5.1.2. Өөрийн хөрөнгийн өгөөж (тайлант хугацааны татварын дараах цэвэр ашгийг ББСБ-ын дүрмийн сантайхарьцуулсан харьцаа);

5.1.3. Шалгалт хамрах хугацаан дахь активын өгөөжийн өсөлт, бууралт (ББСБ-ын ашгийн түвшинг өмнөх он, улирлуудтай харьцуулсан өсөлт бууралт, түүний чиг хандлага, өөрчлөлтийн шалтгааныг тодруулах);

5.1.4. Цэвэр хүүгийн зөрүүний харьцаа (нийт хүүгийн орлого, хүүгийн зардлын зөрүүг ББСБ-ын шалгалт хамрах хугацааны дундаж актив хөрөнгөтэй харьцуулсан харьцаа);

## 5.2. Харгалзах хүчин зүйл

5.2.1. Пассив хөрөнгөд эзлэх хүүд мэдрэмж багатай эх үүсвэрийн хэмжээ;

## ЗУРГАА. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР

Хянан шалгагч нь дараах хүчин зүйлийг үндэслэн энэ журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу ББСБ-ын ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРТ үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

### 6.1. Үндсэн буюу чанарын хүчин зүйл

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын чанарыг үнэлж дүгнэхдээ бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт, бууралтын хандлага, тогтвортой байдал; богино хугацаат, хэлбэлзэл өндөртэй эх үүсвэрээс хамаарах хамаарал, энэхүү богино хугацаат эх үүсвэрээр урт хугацаат активыг санхүүжүүлсэн байдал; актив хөрөнгөд эзлэх хөрвөх чадвар сайтай активын хэмжээ, активыг борлуулах боломж; мөнгөний зах зээлд оролцох болон бусад эх үүсвэр татах чадвар, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах чадвар; төлбөрийн чадвартай холбоотой бодлого, заавар журмын зохистой байдал, түүний хэрэгжилт, эх үүсвэрийн удирдлагын стратеги, удирдлагын мэдээллийн систем болон эх үүсвэр татах нөөц төлөвлөгөө; төлбөрийн чадварын эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах болон ажиглах удирдлагын чадвар, тэнцлийн болон тэнцлийн гадуурх данснууд дахь эх үүсвэрийн хэмжээ зэрэг үзүүлэлтийг харгалзана.

6.1.1. Хорооноос тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдал;

### 6.2. Харгалзах хүчин зүйл



6.2.1. Төлбөрийн чадварын хүндрэл учирч болзошгүй эсэх;

а/ Актив, пассивын удирдлага, тэдгээрийн төлөгдөх хугацааны уялдаа, гадаад актив, пассивын эрсдэлийн харьцаа, зээл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа;

б/ Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөд эзлэх богино хугацаат хөрөнгийн хэмжээ;

в/ Итгэлцэлийн үйлчилгээ, хоёрдогч өглөг болон хаалттай өрийн бичиг гаргах замаар татан өвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Хорооноос баталсан журам, зааварт заасан шаардлагыг хангасан эсэх;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./*

г/ Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийн удирдлага;

~~д/ ББСБ-ын эх үүсвэр татах чадвар~~

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./*

~~е/ Эх үүсвэр татах нооц төлөвлөгөө;~~

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор хүчингүй болгосон./*

6.2.2. Банк, бусад санхүүгийн байгууллага, төслийн санхүүжилтаар авсан зээл нь хугацаандаа төлөгдсөн эсэх;

6.2.3. Төлбөр тооцоо саатуулсан эсэх, саатуулж байсан бол хэмжээ, шалтгаан, шийдвэрлэсэн байдал;

а/ Бусад пассив буюу бусдад төлөх өглөгийн үлдэгдэл;

## ДОЛОО. ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН МЭДРЭМЖ

Хянан шалгагч нь ББСБ-ын өөрийн үйл ажиллагаанд үүсч буй зах зээлийн эрсдэл буюу хүүгийн, ханшийн болон үнийн эрсдэлийг хэрхэн хянаж байгаад дараах хүчин зүйлийг үндэслэн энэ журмын 6 дугаар хавсралтад заасны дагуу ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН МЭДРЭМЖИД үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

7.1. Үндсэн буюу чанарын хүчин зүйл /Ханшийн эрсдэл/

7.1.1. Гадаад валютын позицгийн үзүүлэлтийг нийт болон нэгж валютын хувьд ханган биелүүлж байгаа байдал;

а/ Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтийг ханган биелүүлж байгаа эсэх, тайланд гадаад валютын ханшийн тэгшитгэлийг үнэн зөв тусгадаг эсэх;

7.1.2. Ханшийн тэгшитгэлийн орлогын эрсдэлээр жигнэсэн нийт активт эзлэх хувь;

7.1.3. Санхүүгийн хэрэгсэл, деривативийн үйл ажиллагааны орлогын нийт орлогод эзлэх хувь;

7.2. Харгалзах хүчин зүйл

7.2.1. Удирдлага нь эрсдэлийг тооцох, бууруулах, эрсдэлээс хамгаалах талаар авч байгаа арга хэмжээ;

а/ Удирдлага нь зах зээлийн эрсдэлийг тодорхойлон эрсдэлээс хамгаалах талаар арга хэмжээний талаар урьдчилсан төвлөгөө, бодлого явуулдаг эсэх;

7.2.2. Удирдлагын мэдээллийн систем нь эрсдэлийг тодорхойлох чадвартай эсэх;

а/ ББСБ-ын удирдлагын мэдээллийн систем нь боловсронгуй эсэх, холбогдох мэдээллийг бүрэн ашиглаж байгаа эсэх;

б/ Зах зээлийн үнийн өөрчлөлт, ханшийн хэлбэлзэлтэй уялдуулан цаашдын бодлого, үйл ажиллагааг удирдан явуулж байгаа эсэх;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

в/ Зах зээлийн эрсдэлийн өөрийн хөрөнгөд үзүүлэх нөлөөлөл;

г/ Эрсдэл хүлээж буй нөхцөлд удирдлага эрсдэлийг даван гарах арга, бололцоо, учирсан хохирлыг нөхөх, арилгах чадвартай эсэхээ хэрхэн тооцож үнэлдэг;

д/ Удирдлага нь эрсдэлээ хэрхэн үнэлдэг, эрсдэлийг үнэлэх арга нь боловсронгуй эсэх, ББСБ-ын үйл ажиллагаанд тохирсон эсэх;

## НАЙМ. НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ ӨГӨХ

ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээрх шалгалтын нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг энэ журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу өгөхдөө дараах зарчмыг баримтална. Үүнд:

8.1. Шалгалтын ажлын хэсгийн гишүүд нь батлагдсан ажил үүргийн хуваарийн дагуу өөрсдийн шалгасан журмын зургаан хэсэг тус бүрт, ажлын хэсгийн ахлагчтай хамтран үнэлгээ өгнө.

8.2. Шалгалтын хэсгийн ахлагч нь гишүүдийн хэсэг тус бүрт өгсөн үнэлгээний нийлбэрийн арифметик дунжийг тооцоолон ББСБ-Ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд нэгдсэн үнэлгээ өгч, шалгалтын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурж, улсын байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулна.

8.3. Нэгдсэн үнэлгээний дүнгээс хамаарч ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг дараах байдлаар үнэлнэ. Үнэлгээг өгөхдөө аравтын оронгоор тоймлон тооцно. Үүнд:

8.3.1. Нэгдсэн үнэлгээ 1-ээс 1.5 хүртэл байвал САЙН буюу хэвийнүйл ажиллагаатай;

8.3.2. Нэгдсэн үнэлгээ 1.6-аас 2.5 хүртэл байвал ХАНГАЛТТАЙ буюу цаашид хэвийн үйл ажиллагааявуулах боломжтой;

*/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон./*

8.3.3. Нэгдсэн үнэлгээ 2.6-аас 3.5 хүртэл байвал ДУНД буюу хяналт шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;

8.3.4. Нэгдсэн үнэлгээ 3.6-аас 4.5 хүртэл байвал ХАНГАЛТГҮЙ буюу төлбөрийн чадваргүй болж болзошгүй;

8.3.5. Нэгдсэн үнэлгээ 4.6-аас 5 хүртэл байвал МУУ буюу төлбөрийн чадваргүй;

8.4. Шалгалтын хэсэг тухайн ББСБ-ынүйл ажиллагаанд өгсөн нэгдсэн үнэлгээнд холбогдох үндэслэлийг тодорхой тусгана.

8.5 Шалгалтын ажлын хэсэг нь шалгуулж буй ББСБ-ынүйл ажиллагаа, тухайн болон ирээдүйн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан нэгдсэн үнэлгээг бууруулж эсхүл дээшлүүлж болно. Ингэхдээ чухам ямар нөхцөл байдлыг харгалзсан үндэслэлээ тодорхой зааж, шалгалтын дүгнэлтэд тусгасан байна.

8.6. Энэ журмын 1-6 дугаар хавсралтаар тооцсон үнэлгээг арифметик дунджаар тооцоолох, мөн бусад харгалзах хүчин зүйлийг тусган ББСБ-ынүйл ажиллагаа, санхүүгийн байдалд нэгдсэн үнэлгээ өгч, шалгалтын хэсгийн бүх гишүүд, улсын байцаагч нар гарын үсэг зурж, улсын байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулна.

8.7. Шалгалтын ажлын хэсэг нь шалгалт хийсэн ББСБ-д тухайн ББСБ-ынүйл ажиллагаа, санхүүгийн байдалд өгсөн нэгдсэн үнэлгээ болон шалгалтын акт, материалыг

Бичил санхүүгийн газрын даргад танилцуулахаас өмнө (шаардлагатай тохиолдолд Хорооны хурлаар оруулж хэлэлцүүлэхээс өмнө) танилцуулна.

8.8. Шалгалтаар өгсөн нэгдсэн үнэлгээг тухайн ББСБхүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд үнэлгээтэй танилцсанаас хойш 10 хоногийн дотор Хорооны Улсын Ерөнхий байцаагчид бичгээр гомдол гаргаж болно.

## ЕС. ХАРИУЦЛАГА

9.1. Дунд ба түүнээс доош нэгдсэн үнэлгээ авсан ББСБ-д Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19.2 дахь заалтад заасан шат дараалсан арга хэмжээг авна. Үүнд:

*/Энэ хэсгийг Хорооны 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 234 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/*

9.1.1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар шалгалтын тайлангаар үүрэг өгөх;

9.1.2. Ноцтой зөрчилтэй гэж үзвэл улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэх;

9.1.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон холбогдох хууль, журамд заасны дагуу захиргааны арга хэмжээ авч торгууль ногдуулах;

9.1.4. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан шат дараалсан бусад арга хэмжээ авах.

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

*Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын  
12-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус  
санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт  
хийх журам”-ын 1 дүгээр хавсралт*

### ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ							
1.1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг ханган биелүүлж байгаа эсэх	30 %	Тогтмол биелүүлдэг	3 улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсвэл улирал ээлжлэн биелүүлсэн	Сүүлийн 2 улирал дараалан биелүүлээгүй	Сүүлийн 3 улирлаас дээш хугацаагаар дараалан биелүүлээгүй	
1.2	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг ханган биелүүлж байгаа эсэх	20 %	Тогтмол биелүүлдэг	3 улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсвэл улирал ээлжлэн биелүүлсэн	Сүүлийн 2 улирал дараалан биелүүлээгүй	Сүүлийн 3 улирлаас дээш хугацаагаар дараалан биелүүлээгүй	
1.3	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын зохистой харьцааг ханган биелүүлж байгаа эсэх	20 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн их	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
2	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ							
2.1	Өөрийн хөрөнгөгтэй холбогдон гарсан хууль тогтоомж, журам зааврыг зөрчсөн эсэх	10 %	Зөрчөөгүй	зөрчлийг өдөр тутмын үйл ажиллагааны явцад засах боломжтой	зөрчил гаргасан бөгөөд түүнийгээ засах талаар арга хэмжээ аваагүй	удаа дараа зөрчил гаргасан, түүнийгээ засах талаар арга хэмжээ аваагүй	зөрчил нь санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж байгаа	
2.2	Хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хорооноос тогтоосон хувь	10 %	Зөрчөөгүй	зөрчлийг өдөр тутмын үйл	зөрчил гаргасан бөгөөд түүнийгээ	удаа дараа зөрчил гаргасан, түүнийгээ	зөрчил нь санхүүгийн	

	нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан эсэх, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүн болон хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орсон тухай бүр Хороонд мэдэгдэж зөвшөөрөл авч байсан эсэх			ажиллагааны явцад засах боломжтой	засах талаар арга хэмжээ аваагүй	засах талаар арга хэмжээ аваагүй	байдалд сөргөөр нөлөөлж байгаа	
2.3	Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахдаа Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авсан эсэх, холбогдох журмын шаардлагыг хангаж байгаа эсэх	5 %	Зөрчөөгүй	зөрчлийг өдөр тутмын үйл ажиллагааны явцад засах боломжтой	зөрчил гаргасан бөгөөд түүнийгээ засах талаар арга хэмжээ аваагүй	удаа дараа зөрчил гаргасан, түүнийгээ засах талаар арга хэмжээ аваагүй	зөрчил нь санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж байгаа	
2.4	Хаалттай өрийн бичиг гаргахдаа Хорооноос зөвшөөрөл авсан эсэх, Хорооноос тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэх	5 %	Зөрчөөгүй	зөрчлийг өдөр тутмын үйл ажиллагааны явцад засах боломжтой	зөрчил гаргасан бөгөөд түүнийгээ засах талаар арга хэмжээ аваагүй	удаа дараа зөрчил гаргасан, түүнийгээ засах талаар арга хэмжээ аваагүй	зөрчил нь санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж байгаа	
ҮНЭЛГЭЭ		100 %						

*Жич:* Шалгах өдрийн байдлаар тохируулж гаргасан санхүүгийн тайланг тухайн ББСБ-ын улирлын санхүүгийн тайлантай адилтган тооцно.

*/Энэ хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 530 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон./*

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын  
12-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус  
санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт  
хийх журам”-ын 2 дугаар хавсралт

АКТИВЫН ЧАНАР

ХҮЧИН ЗҮЙЛ	ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ						
1.1	Нийт активт үй чанарг активын эзлэх хувь хэмжээ	10 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр
1.2	Өөрийн хөрөнгөд чанаргүй активын эзлэх хувь хэмжээ	15 %	0,0-9,9 хувь	10,0-29,9 хувь	30,0-60,0 хувь	60,1-99,9 хувь	100.0 хувь болон түүнээс дээш
1.3	Активын эрсдэлийн сангийн байвал зохих хэмжээг өөрийн хөрөнгөд харьцуулсан хувь	20%	5 хувь хүртэл	5-15 хувь	16-30 хувь	31-50 хувь	51-ээс дээш хувь
1.4	Өөрийн хөрөнгөд эзлэх активын өвлөрлийн эрсдэлийн хувь хэмжээ	15 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр
1.5	Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн нийт активт харьцуулсан хувь	10 %	<i>хангасан</i>				<i>хангаагүй</i>
2	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ						
2.1	Нийт активт орлого авчирдаггүй активын эзлэх хувь хэмжээ	5 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр
2.2	Зээлийн бодлогын хэрэгжилт, Зээлийн хорооны үйл ажиллагаа буюу зээлийн эргэн төлөлт /шалгалт хамрах хугацаанд олгосон, төлөгдсөн зээлийн харьцаа/	5 %	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 91-ээс дээш хувь	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 81-90 хувь	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 71-80 хувь	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 61-70 хувь	Зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 60-аас доош хувь

2.3	Зээл болон бусад активт тавьсан хязгаарлалтыг хангаж байгаа эсэх	5 %	хангасан				хангаагүй	
2.4	Эрсдэлтэй активын ангиллыг зохих журмын дагуу хийсэн эсэх	5 %	100 хувь ангилсан	91-ээс дээш хувь ангилсан	71-90 хувь ангилсан	30-50 хувь ангилаагүй	51-ээс дээш хувь ангилаагүй	
2.5	Эрсдэлийн санг зохих журмын дагуу байгуулж, зарцуулсан эсэх	5 %	100 хувь байгуулсан	91-ээс дээш хувь байгуулсан	71-90 хувь байгуулсан	30-50 хувь байгуулаагүй	сангийн дутагдал 51-ээс дээш хувьд хүрсэн	
2.6	Чанаргүй активын өсөлт, бууралтын шалтгааныг тодруулах, чанаргүй активыг барагдуулах талаар авсан арга хэмжээ, өр барагдуулж буй үйл ажиллагаа	5 %						
ҮНЭЛГЭЭ		100 %						

*/Энэ хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон./*



*Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын  
12-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус  
санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт  
хийх журам”-ын 3 дугаар хавсралт*

**УДИРДЛАГЫН ЧАДВАР**

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	<b>ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ</b>							
1.1	Энэхүү журмын бусад 5 үзүүлэлтийн дундаж үнэлгээ /арифметик дундажаар тооцоолно/	30 %						
1.2	Үйл ажиллагааны зардлын үйл ажиллагааны орлогод эзлэх хувийн жин	15 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	
2	<b>ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ</b>							
2.1	Хорооноос газар дээрх шалгалтын үр дүнгээр авсан арга хэмжээний чанар, үр дүнгийн байдал	10 %						
2.2	Эдийн засаг болон санхүүгийн салбарт гарч байгаа өөрчлөлтөд зохицуулан ББСБ-ыг зохион байгуулан удирдах чадвартай эсэх, ББСБ-ын санхүүгийн байдлыг судалж, үнэлэлт дүгнэлт өгөн зөв зохистой шийдвэр гаргадаг эсэх, гүйцэтгэх удирдлага нь холбогдох хуульд заасан шаардлагыг хангасан эсэх	5 %						
2.3	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг цаг алдалгүй арилгуулах талаар арга хэмжээ авдаг эсэх, дотоод хяналтын үйл ажиллагаа нь өөрийн дотоод эрсдэлийг илрүүлэх,	10 %						

	бууруулах, хянахад чиглэгдэж байгаа эсэх							
2.4	Удирдлагын мэдээллийн систем бүрэлдэн бий болсон эсэх, ББСБ-ын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийн талаарх мэдээллийг хэрхэн цуглуулдаг, шаардлагатай бүх мэдээллийг хамардаг, мэдээллийн үнэн зөв эсэхэд хэрхэн хяналт тавьдаг, Монголбанкны мэдээллийн санд холбогдсон эсэх	5 %						
2.5	Холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн дотоод дүрэм, заавар журмыг боловсруулж, тэдгээрийг мөрдөж байгаа эсэх	5 %						
2.6	Удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, ажилтнууд нь албан тушаалаа урвуулан ашиглаж байсан эсэх	5 %						
2.7	Нягтлан бодохүртбэлийн програм хангамжтай эсэх, санхүүгийн тайлан, мэдээг зохих журмын дагуу зөв зохистой гаргадаг эсэх, нягтлан бодох бүртгэлийг Олон Улсын стандартын дагуу гаргахад хяналт тавьдаг эсэх	10 %						
2.8	Мөнгө угаах терроризмтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа эсэх	5 %						
	ҮНЭЛГЭЭ	100 %						

*/Энэ хавсралтад Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 18 -ны өдрийн 530 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон./*

*Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын  
12-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус  
санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт  
хийх журам”-ын 4 дүгээр хавсралт*

**АШИГТ АЖИЛЛАГАА**

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	<b>ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ</b>							
1.1	Активын өгөөж ( <i>Тайлант хугацааны татварын дараах ашиг/Нийт дундаж актив</i> )	25 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
1.2	Өөрийн хөрөнгийн өгөөж ( <i>Тайлант хугацааны татварын дараах ашиг/хувь нийлүүлсэн хөрөнгө</i> )	25 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
1.3	Активын өгөөжийн өсөлт, бууралт	15 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн их өссөн, бага буурсан	Нэгтгэлийн дундажаас дээгүүр өссөн	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур өссөн	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага өссөн, их буурсан	
1.4	Цэвэр хүүгийн зөрүүний харьцаа ((Хүүгийн орлого - Хүүгийн зардал)/Нийт дундаж актив )	15 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн өндөр	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
2	<b>ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ</b>							
2.1	Пассив хөрөнгөд эзлэх хүүд мэдрэмж багатай эх үүсвэр	20 %	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажаас -, + 10 хувиар зөрүүтэй	Нэгтгэлийн дундажаас -20 хувь доогуур	Нэгтгэлийн дундажаас 20-иос дээш хувь доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	
ҮНЭЛГЭЭ		100 %						

*Жич:* Шалгах өдрийн байдлаар тохируулж гаргасан санхүүгийн тайланг тухайн ББСБ-ын улирлын санхүүгийн тайлантай адилтган тооцно.

*Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын  
12-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус  
санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт  
хийх журам”-ын 5 дугаар хавсралт*

### ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР

ХҮЧИН ЗҮЙЛ		ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ							
1.1	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг ханган биелүүлж байгаа байдал	40 %	Тогтмол биелүүлдэг	3 улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсвэл улирал ээлжлэн биелүүлсэн	Сүүлийн 2 улирал дараалан биелүүлээгүй	Сүүлийн 3 улирлаас дээш хугацаагаар дараалан биелүүлээгүй	
2	ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ							
2.1	Төлбөрийн чадварын хүндрэлд орж болзошгүй эсэх	30 %	хүндрэлээс бүрэн хамгаалагдсан	1 жилээс дээш хугацааны дараа хүндрэлд орж болзошгүй	2 улирлаас 1 жил хүртэл хугацааны дотор орж болзошгүй	2 улирлын хугацааны дотор орж болзошгүй	ойрын 1 улирлын хугацаанд хүндрэлд орох магадлалтай	
2.2	Банк, бусад санхүүгийн байгууллага, төслийн санхүүжилтаар авсан зээл нь хугацаандаа төлөгдсөн эсэх	20 %	тийм	-	-	-	үгүй	
2.3	Төлбөр тооцоо саатуулсан, эс саатуулсан байдал	10 %	саатуулж байгаагүй	саатуулж болзошгүй	1 улирал саатуулсан	2 улирал саатуулсан	3-аас дээш улирал саатуулсан	
ҮНЭЛГЭЭ		100 %						

*Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын  
12-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус  
санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт  
хийх журам”-ын 6 дугаар хавсралт*

**ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН МЭДРЭМЖ**

ХҮЧИН ЗҮЙЛ	ЖИГНЭХ ХУВЬ	САЙН /1/	ХАНГАЛТТАЙ /2/	ДУНД /3/	ХАНГАЛТГҮЙ /4/	МУУ /5/	ҮНЭЛГЭЭ
1	<b>ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ</b>						
1.1	Гадаад валютын позиц ийн үзүүлэлтийг нийт валютын хувьд ханган биелүүлж байгаа байдал	25 %	Тогтмол биелүүлдэг	3 улирал дараалан биелүүлсэн	2 улирал эсвэл улирал ээлжлэн биелүүлсэн	Сүүлийн 2 улирал дараалан биелүүлээгүй	Сүүлийн 3 улирлаас дээш хугацаагаар дараалан биелүүлээгүй
1.2	Гадаад валютын позиц ийн үзүүлэлтийг нэгж валютын хувьд ханган биелүүлж байгаа байдал	20 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн хамгийн өндөр
1.3	Ханшийн тэгшитгэлийн орлогын эрсдэлээр жигнэсэн нийт активт эзлэх хувь	20 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн их	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага
1.4	Санхүүгийн хэрэгсэл, деривитивийн үйл ажиллагааны орлогын нийт орлогод эзлэх хувь	10 %	Нэгтгэлийн дундажийн хамгийн их	Нэгтгэлийн дундажаас дээгүүр	Нэгтгэлийн дундажтай тэнцүү	Нэгтгэлийн дундажаас доогуур	Нэгтгэлийн дундажийн хамгийн бага
2	<b>ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ</b>						
2.1	ББСБ-ын удирдлага нь эрсдэлийг тооцох, бууруулах, эрсдэлээс хамгаалах талаар авч байгаа арга хэмжээ	15 %	Эрсдэлийг удирдах бүрэн боломжтой	Арга хэмжээ нь үр дүнтэй	Арга хэмжээ нь зарим талаар үр дүнтэй	Арга хэмжээ нь үр дүн багатай	Эрсдэлийг удирдах бүрэн боломжгүй
2.2	Удирдлагын мэдээллийн	10 %	Чадвартай				Чадваргүй

систем нь эрдэлийг тодорхойлох чадвартай эсэх								
ҮНЭЛГЭЭ	100 %							

*Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын  
12-ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус  
санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт  
хийх журам”-ын 7 дугаар хавсралт*

**ББСБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН  
БАЙДАЛД ӨГСӨН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ**

ДД	ҮЗҮҮЛЭЛТҮҮД		ЖИГНЭХ ХУВЬ	ШАЛГАЛТААР ӨГСӨН ҮНЭЛГЭЭ		ӨМНӨХ ШАЛГАЛТААР ӨГСӨН ҮНЭЛГЭЭ	ӨӨРЧЛӨЛТ
				Үзүүлэлтээр	Жигнэснээр		
1	ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ	С	25 %				
2	АКТИВЫН ЧАНАР	А	25 %				
3	УДИРДЛАГЫН ЧАДВАР	М	10 %				
4	АШИГТ АЖИЛЛАГАА	Е	20 %				
5	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР	Л	10 %				
6	ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН МЭДРЭМЖ	С	10 %				
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ			100 %				

Жич: 1. Бууруулсан эсхүл дээшлүүлсэн үнэлгээ бүрийн харгалзах үндэслэлийг тодорхой зааж бичнэ.

ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:

ШАЛГАЛТЫН ХЭСГИЙН АХЛАГЧ .....

./НЭР/

ШАЛГАЛТЫН ХЭСГИЙН ГИШҮҮД: .....

./НЭР/